



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/57

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Иргэний нисэхийн ерөнхий газрын "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 5.15, 7.22 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Америкийн Нэгдсэн Улсын "Холбооны нисэхийн захиргаа"-аас хийгдэх Нисэхийн аюулгүй ажиллагааны аудитын шалгалт болон Техникийн урьдчилсан үнэлгээнд хамрагдах бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар байгуулсугай.

2. Америкийн Нэгдсэн Улсын "Холбооны нисэхийн захиргаа"-аас хийгдэх Нисэхийн аюулгүй ажиллагааны аудитын шалгалт болон Техникийн урьдчилсан үнэлгээнд хамрагдах бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийн удирдамжийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

3. Ажлын хэсгийн нэгдсэн төлөвлөгөө, төсвийг 2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор батлуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулан, ажлын явцын талаар Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын зөвлөлд сар бүр тайлагнахыг ажлын хэсгийн дарга (П.Ганболд)-д даалгасугай.

4. Ажлын хэсгийн үйл ажиллагааг үр дүнтэй, тасралтгүй хэвийн явуулах зорилгоор үндсэн цалингийн 20 хувийн нэмэгдэл хөлсийг ажлын хэсгийн даргад, ажлын үр дүнг харгалзан 20 хүртэл хувийн нэмэгдэл хөлсийг нарийн бичиг, гишүүдэд 2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс сар бүр олгох, зардлыг төсвийн дагуу гарган зарцуулахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Д.Хатанбаатар)-т зөвшөөрсүгэй.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Т.Батжаргал)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.МӨНХТУЯА

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын  
2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн  
vt./91 дугаар тушаалын ... дугаар хавсралт



## АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

### 1. Ажлын хэсгийн зорилго:

Америкийн Нэгдсэн Улсын "Холбооны нисэхийн захиргаа"-аас хийгдэх Нисэхийн аюулгүй ажиллагааны аудит шалгалт болон Техникийн урьдчилсан үнэлгээнд хамрагдах бэлтгэл ажлыг хангуулахад ажлын хэсгийн зорилго оршино.

### 2. Хамрах хүрээ:

Иргэний нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын орчныг чадавхжуулах, Иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцын Хавсралтуудад тусгагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу Америкийн Нэгдсэн Улсын "Холбооны нисэхийн захиргаа"-аас хийгдэх Нисэхийн аюулгүй ажиллагааны аудит шалгалтын болон Техникийн урьдчилсан үнэлгээнд амжилттай хамрагдах бэлтгэл ажлыг дараах 8 чухал элементийн хүрээнд хангах. Үүнд:

Чухал элемент	Нэр	Төлөв
CE-1	Нисэхийн үндсэн хууль тогтоомж /Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хууль /	Тогтолцоог бий болгох
CE-2	Зохицуулалтын дүрэм, журмууд /ИНБД/	
CE-3	Иргэний нисэхийн тогтолцоо ба аюулгүй ажиллагааг удирдах эрх бүхий байгууллага	
CE-4	Аюулгүй ажиллагааны хяналтын байцаагч, тэдгээрийн мэргэшил, сургалт	
CE-5	Техникийн гарын авлага, заавар журам болон туслах хэрэгслүүд	
CE-6	Тусгай зөвшөөрөл, гэрчилгээ, үнэмлэх олгох	Хэрэгжилтийг тогтмол хангах
CE-7	Аюулгүй ажиллагааны байнгын хяналтын тогтолцоо	
CE-8	Аюулгүй ажиллагаанд нөлөөлж болзошгүй асуудлыг шийдвэрлэх, холбогдох арга хэмжээ авах-	



### **3. Ажлын хэсгийн хэрэгжүүлэх арга хэмжээ:**

Ажлын хэсэг нь авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангуулахдаа дараах үйл ажиллагааг хамрах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:

3.1. АНУ-ын Холбооны нисэхийн захиргаа (цаашид FAA гэх) Нисэхийн аюулгүй ажиллагааны аудитын (цаашид IASA гэх) шалгах хуудаснуудын дагуу холбогдох нэгж хэлтсүүд урьдчилсан байдлаар өөрсдийгөө үнэлэх (Self Assessment) ажлыг нэн яаралтай горимоор хийж авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох, төлөвлөгөөг 2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор батлуулах;

3.2. Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтыг чадавхжуулах, Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас тавьж буй аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын стандартыг хэрэгжүүлэх, FAA IASA аудит шалгалтад бэлтгэлийг хангуулах хүрээнд гадны зөвлөх үйлчилгээ үзүүлэх компанийн ажлын даалгаврыг боловсруулах, гэрээ хэлцэл байгуулах, хамтарч ажиллах;

3.3. Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Ази, Номхон далайн бүсийн оффис болон Ази, Номхон далайн бүсийн орнуудын Нисэхийн аюулгүй ажиллагааны хамтын ажиллагааны хөтөлбөр /COSCAP-NA/-тэй хамтран ажиллах, зөвлөгөө авах, шаардлагатай сургалтуудыг зохион байгуулах;

3.4. Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2022 оны А/319 тоот тушаалаар томилогдсон, Олон Улсын Иргэний Нисэхийн Байгууллагын Нисэхийн аюулгүй ажиллагааны аудит шалгалт болон Америкийн Нэгдсэн Улсын Холбооны Нисэхийн захиргаанаас хийгдэх Нисэхийн аюулгүй ажиллагааны аудит шалгалтын бэлтгэл ажлыг хангуулах үндсэн ажлын хэсэгтэй хамтран ажиллах;

3.5. “Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”-ийг Чикагогийн конвенц, түүний Хавсралтууд болон /ICAO/-ийн баримт бичиг Док.9734 “Аюулгүй ажиллагааны хяналтын заавар”-ын хэрэгжилтийг бүрэн хангахуйц хэмжээнд боловсруулагдсан эсэхэд үнэлгээ хийж, шаардлагатай нэмэлт өөрчлөлтүүдийг тусгах (CE-1, CE-8, CE-5);

3.6. Иргэний нисэхийн хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийх давтамж, аргачлал, нэгжийг тодорхой болгох, журам, зааврыг боловсруулах;

3.7. Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас гаргасан аюулгүй ажиллагааны стандарт, практик зөвлөмжид нэмэлт өөрчлөлт орсон тухай бүр үнэлгээ хийж, иргэний нисэхийн дүрэмд өөрчлөлт орж буй эсэх, журмын хэрэгжилтийг нягтлах, шаардлагатай журам зааврыг боловсруулах, сургалт, танилцуулга хийх; /Хавсралт 1, 6, 8-ын өөрчлөлтүүдийг батлагдсан ИНД-д тусгагдсан эсэхийг нягтлах, тусгах, арга хэмжээ авах/



3.8. Дүрмийн шаардлагаас чөлөөлөх процедурыг сайжруулах шаардлагатай бол Аюулгүйн зөвлөлийн ажиллах журмыг шинэчлэх;

3.9. Иргэний нисэхийн багц дүрэм, зөвлөмжийн цуврал зэрэг зохицуулалтын орчны баримт бичгүүдэд нэмэлт өөрчлөлт, сайжруулалт хийгдсэн байдал, баримталсан бодлого зарчимд үнэлгээ хийж, тодорхой давтамжтайгаар судалгаа, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр ИНБД-д нэмэлт өөрчлөлт оруулж байх зөв тогтолцоог бий болгох; (СЕ-2)

3.10. Иргэний нисэхийн ерөнхий газар, иргэний нисэхийн хяналт, зохицуулалтын орчны хүрээнд хүний нөөцийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлж, тогтвор суурьшилтай ажиллуулах тогтолцоог бий болгоход чиглэсэн журам, заавар боловсруулах, батлуулах; (СЕ-3)

3.11. Аюулгүй ажиллагааны хяналтын чиг үүргийг үр дүнтэй гүйцэтгэх чадварлаг, мэргэшсэн байцаагчийг бий болгоход чиглэсэн "Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагчийг чадавхжуулах цогц хөтөлбөр" боловсруулж, батлуулах; (СЕ-4)

3.12. Аюулгүй ажиллагааны хяналтын байцаагчийн хяналт шалгалтын үйл ажиллагааг цахим болгох, программ хангамжийн хөгжүүлэлтэд дэмжлэг үзүүлэх, процедур заавар, журам боловсруулах; (СЕ-5, СЕ-6, СЕ-7)

3.13. Иргэний нисэхийн хууль, дүрмийг албадан хэрэгжүүлэх үйл ажиллагааг сайжруулах, Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх, иргэний нисэхийн үйл ажиллагаатай холбоотой зөрчлийг ангилж, шийтгэлийн хэмжээг шинэчлэн Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд тусгуулах талаар арга хэмжээ авах; (СЕ-8)

3.14. Иргэний нисэхийн ерөнхий газрын нэрийн өмнөөс аюулгүй ажиллагааны хяналт, шалгалтыг хийж, аюулгүй ажиллагааны стандарт шаардлага хангасан гэдгийг бататгах үүрэг бүхий итгэмжлэгдсэн шалгагч, гэрээт байцаагчдад тавигдах шаардлага, сонгох шалгаруулах шалгуур, гэрээ байгуулж үүрэгжүүлэх болон ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам, заавар боловсруулах, батлуулах; (СЕ-3, СЕ-6, СЕ-7)

3.15. НААХЗА-ны үйл ажиллагааны ерөнхий журам, аюулгүй ажиллагааны хяналт шалгалтын ерөнхий журам, гэрчилгээжүүлэлтийн ерөнхий журам, хяналтын хуудасны бодлого, зарчим, хэрэглэх аргачлал, индексжүүлэлт зэрэг НААХЗА-ны үйл ажиллагааны дэг горим, процедурыг боловсруулах батлуулах, хэлтсүүдийн үйл ажиллагааны заавруудад нэмэлт өөрчлөлт оруулах;

3.16. НСҮАХХ, НТЧХ, ҮГХ-ийн хамтын ажиллагааны талаарх зохицуулалт сул байгааг сайжруулах, хэлтсүүдийн зааврын уялдаа холбоог нягтлах, хэрэгжилтэд хяналт тавих, холбогдох арга хэмжээ авах;

3.17. Боловсруулж батлуулсан журам, заавар, аргачлалын хүрээнд сургалт, шалгалт зохион байгуулах;

3.18.Ажлын хэсгийн гишүүд багш байцаагч болох, Иргэний нисэхийн сургалтын төвд хийгдэх боломжтой сургалтын нэр, төрөл, хөтөлбөрийг боловсруулах, батлуулах, сургалт зохион байгуулах;

3.19.Агаарын тээвэрлэгч, агаарын хөлгийн үйл ажиллагаатай хамааралтай болон бусад тусгай (particular operation) зөвшөөрөл олгосон нотлох баримтуудыг бүрдүүлэх; /агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ, агаарын хөлгийн техник үйлчилгээний хөтөлбөр, техник үйлчилгээний эрх, агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвар, НТЧ хадгалалт, шинэ агаарын хөлөг нэмэгдэх, түрээс, ETOPS, ETOD, RVSM, CAT 1, CAT 2 гэх мэт/

3.20.83 bis - хэрэгжилтэд хамаарах зохицуулалтын баримт бичиг /хууль, дүрэм, журмууд/-т нарийвчилсан дүн шинжилгээ хийх, шаардлагатай журам, заавар боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг хангах.


#### **4.Тайлагнах:**

4.1.Ажлын хэсгийн дарга нь төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, ажлын явцын тайланг Даргын зөвлөлд сар бүр танилцуулна.

4.2. Ажлын хэсэг нь төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, ажлын хэсгийн нэгдсэн тайланг Даргын зөвлөлд 2023 оны 12 дугаар сарын 29-ний дотор тайлагнана.



Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын  
2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн  
А.С. дугаар тушаалын 01 дүгээр хавсралт



## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн  
дарга:

П.Ганболд

(Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт,  
зохицуулалтын албаны дарга бөгөөд Нисэхийн  
аюулгүй ажиллагааны хяналтын Улсын ерөнхий  
байцаагч)

Ажлын хэсгийн  
гишүүд:

Ё.Энхтөр

(Хууль, эрх зүй дүрмийн боловсруулалтын  
газрын Дүрмийн боловсруулалтын тасгийн  
дарга)

Б.Хүдэрчулуун

(Нислэгт тэнцэх чадварын хэлтсийн дарга  
бөгөөд нисэхийн аюулгүй ажиллагааны  
хяналтын байцаагч)

Б.Билгүүдэй

(Нислэгийн стандарт, үйл ажиллагааны  
хяналтын хэлтсийн дарга бөгөөд нисэхийн  
аюулгүй ажиллагааны хяналтын байцаагч)

Н.Заяа

(Үнэмлэх, гэрчилгээжүүлэлтийн хэлтсийн дарга  
бөгөөд нисэхийн аюулгүй ажиллагааны  
хяналтын байцаагч)

Г.Мөнхболд

(Аэродром, агаарын навигацийн хяналтын  
хэлтсийн дарга бөгөөд нисэхийн аюулгүй  
ажиллагааны хяналтын байцаагч)

Г.Ганхуяг

(Нислэгт тэнцэх чадварын хэлтсийн нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын ахлах байцаагч)

Х.Эвсанаа

(Нислэгийн стандарт, үйл ажиллагааны хяналтын хэлтсийн ахлах байцаагч)

Ч.Дарьсүрэн

(Нислэгийн стандарт, үйл ажиллагааны хяналтын хэлтсийн нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын ахлах байцаагч)

П.Ганзориг

(Нислэгт тэнцэх чадварын хэлтсийн нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын ахлах байцаагч)

П.Батсайхан

(Нислэгт тэнцэх чадварын хэлтсийн нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын ахлах байцаагч)

П.Ганбаатар

(Аэродром, агаарын навигацийн хяналтын хэлтсийн нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын ахлах байцаагч)

Б.Анхбаяр

(Аэродром, агаарын навигацийн хяналтын хэлтсийн нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын ахлах байцаагч)

Д.Мөнгөнхүү

(Үнэмлэх, гэрчилгээжүүлэлтийн хэлтсийн нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын ахлах байцаагч)

Б.Тулга

(Үнэмлэх, гэрчилгээжүүлэлтийн хэлтсийн нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагч)

З.Амарсанаа

(Нислэгийн стандарт, үйл ажиллагааны  
хяналтын хэлтсийн нисэхийн аюулгүй  
ажиллагааны хяналтын байцаагч)

Э.Алтангэрэл

(Нислэгийн стандарт, үйл ажиллагааны  
хяналтын хэлтсийн нисэхийн аюулгүй  
ажиллагааны хяналтын байцаагч)

Д.Сувдаа

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Захиргаа,  
хүний нөөцийн газрын менежер)

П.Батбаяр

(Хууль, эрх зүй, дүрмийн боловсруулалтын  
газрын хуулийн мэргэжилтэн)

Ш.Төмөрпүрэв

(Хууль, эрх зүй дүрмийн боловсруулалтын  
газрын Дүрмийн боловсруулалтын тасгийн  
мэргэжилтэн)

Нарийн бичгийн  
дарга:

Н.Ганчимэг

(Үнэмлэх, гэрчилгээжүүлэлтийн хэлтсийн  
нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын  
байцаагч)

Г.Сэржмядаг

(Нислэгт тэнцэх чадварын хэлтсийн  
мэргэжилтэн)

Д.Алтан-Очир

(Нислэгийн стандарт, үйл ажиллагааны  
хяналтын хэлтсийн мэргэжилтэн)